



**АЛСЫН ХАРАА:** ЭРҮҮЛ АРЬС-ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ

**ЭРХЭМ ЗОРИЛГО:**

**ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРСЭН АРЬС-ХАРШИЛ, ЭМЧИЛГЭЭНИЙ ГОО ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ**

**ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС:**

- *Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж-Бидний итгэл, найдвар*
- *Үйлчлүүлэгчийн арьсны эрүүл мэнд- Бидний чанарын баталгаа*
- *Үйлчлүүлэгчийн эдгээрэлт –Бидний дэвшил, хөгжил*
- *Үйлчлүүлэгчийн инээмсэглэл-Бидний ёс зүй, хариуцлага*

**БИДНИЙ ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ**

- *Зөв хандлага, хүндлэлд суурилсан соёлтой*
- *Үйл явц нь хэрэгцээнд суурилсан, оновчтой*
- *Гүйцэтгэл нь үр дүнтэй, үр ашигтай*
- *Тусламж, үйлчилгээ нь аюулгүй, чанартай*
- *Хүний нөөц чадварлаг, мэдрэмжтэй*
- *Хагас бие даасан тогтолцоотой*

**БИДНИЙ ӨДӨР ТУТАМ МӨРДӨХ ДҮРЭМ:**

- *Алсын хараа, эрхэм зорилгоо дээдэлнэ.*
- *Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллана.*
- *Арьс харшил, эмчилгээний гоо заслын эрэлт хэрэгцээнд тулгуурлана.*
- *Тасралтгүй суралцагч байгууллага байж, Үндэсний хэмжээний арьс харшил, гоо заслын эмч, мэргэжилтэн чанартай бэлтгэнэ.*
- *Тусламж, үйлчилгээ нь шинэ санаа, шинэ мэдлэг, дэвшилтэт технологи, нотолгоонд суурилна.*
- *Мэргэшсэн өндөр чадавхтай багаар ажиллан, шилдэг үйлчилгээг хүргэнэ.*
- *Удирдлага, хамт олны манлайлал, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг эрхэмлэнэ.*

**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛӨӨР  
ХЭЛЭЛЦЭН, БАТЛАВ.**

**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2019-2023 ОН )**

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 1. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ									
<i>Стратегийн зорилго 1. Үйлчлүүлэгчдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх</i>									
<i>Стратегийн зорилт 1.1.1. Үйлчлүүлэгчдэд арьс харшлын өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх</i>				<i>Хүрэх үр дүн: Үйлчлүүлэгчдийн арьс харшлын эмгэгийн талаарх эрүүл мэндийн боловсрол сайжирна.</i>					
Дэс дугаар	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх түвшин	хугацаа					Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт
			2019	2020	2021	2022	2023		
1.1.1.1	Арьс харшлын чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны өнөөгийн байдлыг үнэлэх	Сургалтын алба Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	+				+	Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох нотолгоо, мэдээлэлтэй болно.	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний тайлан</li> <li>• Зөвлөмж</li> </ul>
1.1.1.2	Үндэсний хөтөлбөрүүдийн тодорхой заалтуудыг хэрэгжүүлэх	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	+	+	+	+	+	АӨСҮТ-ийн хэрэгжүүлэх шаардлагатай онцлог үйл ажиллагаанууд хэрэгжинэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Батлагдсан төлөвлөгөө</li> <li>• Хэрэгжилтийн тайлан</li> </ul>
1.1.1.3	Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн МСС-ны материал, гарын авлага боловсруулан, түгээх	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	+	+	+	+	+	Үйлчлүүлэгчид МСС-ны гарын авлага, мэдээллээр хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>• Гарын авлага, сурталчилгааны материалын түгээлтийн тоо</li> </ul>
1.1.1.4	Арьс харшлын эрүүл мэндийн цуврал хичээлүүдийг хүлээлгийн танхим, амбулатори, тасаг нэгжийн ТВ-ээр тасралтгүй хүргэх	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	+	+	+	+	+	Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн тоо</li> <li>• Тайлан</li> </ul>

1.1.1.5	Үйлчлүүлэгчдэд арьс харшлын өвчний үеийн хооллолт, хүнсний гаралтай харшлын өвчний талаар МСС хийх	Хоол зүйч	+	+	+	+	+	Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Хоол, хүнсний харшлын талаар МСС-ны тоо</li> </ul>
1.1.1.6	Төвийн цахим сайтад НЭМ-ийн МСС-ны булан нээж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	+	+	+	+	+	Иргэд ЭМ-ийн мэдээллээр тогтмол хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>• Сайтад тавигдсан мэдээллийн тоо</li> <li>• Үр дүнгийн мэдээлэл</li> </ul>
1.1.1.7	Шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч нарт зориулсан ухуулга, сурталчилгааны баримтын хуудас боловсруулан түгээж, мэдээлэл хүргэх	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан			+		+	Шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчид арьс харшлын өвчний талаар нотолгоо, баримт мэдээлэлтэй болно.	<ul style="list-style-type: none"> <li>• Баримтын хуудас</li> <li>• Түгээсэн тоо</li> </ul>
<b>Стратегийн зорилт 1.1.2 Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээний үр дүнг сайжруулах</b>			<b>Хүрэх үр дүн: Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээний үр дүн сайжирна.</b>						
1.1.2.1	Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн үр дүнг сайжруулах	Зөвлөх поликлиник	+	+	+	+	+	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн үр дүн сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>• Үзлэгийн тайлан мэдээ</li> <li>• Хяналтын өвчтөний нэмэгдсэн хувь</li> <li>• Эмчлэн эрүүлжүүлсэн хувь</li> </ul>
1.1.2.2	Ядуу, эмзэг бүлгийн хүн амд арьс харшлын эмгэгийн үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх кампанит ажлыг төлөвлөгөөтэй зохион байгуулах	Зөвлөх поликлиник			+		+	Ядуу, эмзэг бүлгийн хүн амын дундах арьс харшлын өвчний тусламж, үйлчилгээ сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>• Батлагдсан төлөвлөгөө</li> <li>• Хэрэгжилтийн тайлан</li> </ul>
1.1.2.3	Амбулаторийн лавлагаа мэдээллийн хэсэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн аппарат, хэрэгсэл байршуулах	Зөвлөх поликлиник			+		+	Хэрэглэгч өөрсдөө артерийн даралт, биеийн жин, өөх тос, уургаа хянах боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Автомат даралт хэмжигч</li> <li>• Биеийн жин хэмжигч</li> <li>• Өөх тос уураг хэмжигч</li> <li>• Өндөр хэмжигч байрлуулсан тоо</li> </ul>
1.1.2.4	Нийгэм-сэтгэл зүй, арьс арчилгааны тусламжийг гэрээр үзүүлэх	Сувилахуйн алба			+		+	Диспансерын хяналтад байдаг үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сувилагчийн баг</li> <li>• Гэрээр тусламж үзүүлсэн тоо</li> </ul>
1.1.2.5	Амбулаторийн үйлчлүүлэгчдийн арьс харшлын эрүүл мэндийн хэрэгцээг асуумжаар болон санал, хүсэлтийг хүлээн авах арга хэлбэрээр тасралтгүй судлах	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	+	+	+	+	+	Эрэлт, хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Эрэлт, хэрэгцээг судалсан тайлан</li> <li>• Авсан арга хэмжээ</li> </ul>

1.1.2.6	Хэвтэн эмчлүүлэгчдэд арьс харшил, эмчилгээний гоо заслын цуврал сургалт хийх	Сургалтын алба	+	+	+	+	+	Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Цуврал сургалтын хөтөлбөр</li> <li>Хамрагдсан хүний тоо</li> </ul>
<b>СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ</b>									
<b>Стратегийн зорилго 2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх</b>									
<b>Стратегийн зорилт 2.1.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх</b>					<b>Хүрэх үр дүн: Тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэн, хүлээгдэл буурна.</b>				
2.1.1.1	Амбулаторийн кабинетуудыг төрөлжүүлэн зохион байгуулах	Удирдлагын зөвлөл	+	+	+	+	+	Амбулаторийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийн кабинет</li> <li>Арьс харшлын кабинет</li> <li>Мөөгөнцрийн кабинет</li> <li>.....</li> </ul>
2.1.1.2	Тусламж, үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг судлан, шийдвэрт ашиглах	Эрдэм, шинжилгээ судалгааны баг	+		+		+	Тусламж, үйлчилгээний ачаалал, хүлээгдлийн талаарх нотолгоо, мэдээллээр хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Ачааллын судалгааны тайлан</li> <li>Шийдвэрт ашигласан мэдээ, тайлан</li> </ul>
2.1.1.3	Цаг товлох болон эмчээ сонгон үзүүлдэг тогтолцоог нэвтрүүлэх	Удирдлагын зөвлөл	+	+				Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Батлагдсан заавар, журам</li> <li>Үр дүнгийн тайлан</li> </ul>
2.1.1.4	Амбулаторийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Зөвлөх поликлиник			+	+	+	Арьс, харшлын тусламж, үйлчилгээний хүрээ өргөжнө.	<ul style="list-style-type: none"> <li>Арьсны мэс ажилбар хийсэн тоо</li> <li>Хөлийн арьсны арчилгааны эмчилгээ хийсэн тоо</li> <li>Арьс цайх өвчний эмчилгээ хийсэн тоо</li> <li>.....</li> </ul>
2.1.1.5	Эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Эмчилгээний гоо заслын тасаг	+	+	+	+	+	Эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li><b>Шинээр нэвтрүүлсэн нэр төрөл</b></li> </ul>
2.1.1.6	Өдрийн эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Зөвлөх поликлиник			+	+	+	Өдрийн тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Нэмэгдсэн орны тоо</li> <li>Хамрагдсан хүний тоо</li> </ul>
2.1.1.7	Амбулаторийн тусламж, үйлчилгээний эмнэл зүйн удирдамж боловсруулан, батлуулах, хэрэгжилтийг хангах	Зөвлөх поликлиник	+	+	+	+	+	Шинэчилсэн эмнэл зүйн удирдамжаар хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Батлагдсан эмнэл зүйн удирдамжийн тоо</li> <li>Хэрэгжүүлсэн мэдээ</li> </ul>
2.1.1.8	Нөхөн сэргээх, эмийн бус эмчилгээнд дэвшилтэт арга хэрэгслийг шинээр нэвтрүүлэх	Зөвлөх поликлиник			+	+	+	Эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li><b>Шинээр нэвтэрсэн нөхөн сэргээх эмчилгээний тоо</b></li> </ul>

2.1.1.9	Лабораторийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Лабораторийн тасаг	+	+	+	+	+	Лабораторийн шинжилгээний нэр төрөл нэмэгдэн, оношилгоо сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Лабораторийн шинжилгээний нэр төрөл нэмэгдсэн үзүүлэлт</li> </ul>	
2.1.1.10	Амбулаторийн зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх	Зөвлөх поликлиник	+	+	+	+	+	Эдийн засгийн үр ашиг гарна.	<ul style="list-style-type: none"> <li>Эрх зүйн орчин</li> <li>Хэрэгжилтийн тайлан</li> </ul>	
2.1.1.11	Диспансерын хяналтын өвчтөнд гэрийн эмчилгээ, сувилгаа хийхэд ар гэрийнхэнтэй хамтран ажиллах	Зөвлөх поликлиник	+	+	+	+	+	Өвчтөний эмнэлгээс гарсны дараах хяналт сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Хамтын төлөвлөгөөний хэрэгжилт</li> <li>Үр дүнгийн мэдээлэл</li> </ul>	
2.1.1.12	Оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийн мөрдөлтөд үнэлгээ хийж, зөвлөмжийн дагуу арга хэмжээ авах	Чанарын алба Сувилахуйн алба				+	+	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний тайлан</li> <li>Зөвлөмжийн хэрэгжилт</li> </ul>	
2.1.1.13	Лабораторийн шинжилгээний гадаад, дотоод хяналтын тасралтгүй байдлыг хангах	Лабораторийн тасаг	+	+	+	+	+	Шинжилгээний хяналт сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Шинжилгээний хяналтын тоо</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>	
2.1.1.14	Хүүхдэд цусаар үздэг харшлын сорилуудыг даатгалд оруулах санал, арга хэмжээг зохион байгуулах	Лабораторийн тасаг	+	+				Хүүхдэд цусаар үздэг харшлын сорилын чанар, хүртээмж нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Авсан арга хэмжээ, мэдээлэл</li> </ul>	
<b>Стратегийн зорилт 2.1.2</b> Хүлээн авах, яаралтай тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, бүтэц, тусламж, үйлчилгээг сайжруулах			<b>Хүрэх үр дүн:</b> Яаралтай үеийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, тусламж, үйлчилгээ сайжирна.							
2.1.2.1	Хүлээн авах, яаралтай тусламжийн нэгж байгуулах	Удирдлагын зөвлөл	+					Хүлээн авах, яаралтай тусламжийн нэгжтэй болно.	<ul style="list-style-type: none"> <li>Шийдвэр</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>	
2.1.2.2	Хүлээн авах яаралтай тусламжийн үүрэг, даалгаврын журам боловсруулан, хэрэгжилтийг хангах	Удирдлагын зөвлөл Чанарын алба	+	+	+	+	+	Хүлээн авах, яаралтай тусламжийн тусламж, үйлчилгээ сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Батлагдсан журам</li> <li>Үйл ажиллагааны үзүүлэлт</li> </ul>	
2.1.2.3	Эмч, мэргэжилтнүүдийг яаралтай амь тэнссэн үеийн тусламж үзүүлэх чадавхад сургах	Сургалтын арга зүйч	+	+	+			Яаралтай, амь тэнссэн үеийн тусламжийг чадавх сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын тоо</li> <li>Хамрагдсан хүний тоо</li> <li>Үр дүнгийн тайлан</li> </ul>	
2.1.2.4	Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг шаардлагатай нөөцөөр хангах	Удирдлагын зөвлөл	+	+	+	+		Эрчимт эмчилгээний чанар сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэшсэн хүний нөөцөөр хангасан тоо</li> <li>Шаардлагатай нөөцөөр хангасан тоо</li> </ul>	
2.1.2.5	Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний өрөөтэй болох	Удирдлагын зөвлөл	+					Яаралтай, эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээний чанар сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Өрөөгөөр хангасан шийдвэр</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>	

2.1.2.6	Зориулалтын тоноглогдсон автомашинтай болох автопаркийн шинэчлэлийг үе шаттай хийх	Санхүү, аж ахуйн алба		+		+			Тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Тоноглогдсон автомашин</li> <li>• Авраг тосон сувилалд ачаа тээвэрлэх автомашины тоо</li> </ul>
<b>Стратегийн зорилт 2.1.3. Чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах</b>			<b>Хүрэх үр дүн: Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хангагдана.</b>							
2.1.3.1	Магадлан итгэмжлэлийн чанарын баталгаа, шалгуурын тасралтгүй байдлыг хангаж ажиллах	Чанарын алба Бүх тасаг нэгж	+	+	+	+	+		Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тасралтгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>• Магадлан итгэмжлэлийн зөвлөмж, шалгуурын хэрэгжилтийн хувь</li> <li>• Магадлан итгэмжлэлийн явцын хяналтын үнэлгээ</li> </ul>
2.1.3.2	Ажилчдын АБТ-д чанар, аюулгүй байдлыг хангах хариуцлагын заалт тусгах	ХНМ Тасаг, нэгжийн удирдлагууд	+	+					Үүрэг, даалгаврын хариуцлага сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>• АБТ тусгагдсан заалт</li> </ul>
2.1.3.3	Дотоод баримт бичгийн нэгдсэн кодын систем нэвтрүүлэх	Чанарын алба Тасаг нэгжийн удирдлагууд			+	+			Дотоод баримт бичгийн нэгдсэн кодын систем нэвтэрнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Баримт бичгийн кодын системийн сургалтын тоо</li> <li>• Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</li> </ul>
2.1.3.4	Эмчилгээ, үйлчилгээнд гарсан алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх	Чанарын алба Тасаг нэгжийн удирдлагууд	+	+	+	+	+		Эрсдэлээс сэргийлэх боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Алдаа зөрчилд дүн шинжилгээ хийсэн тоо</li> <li>• Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан тоо</li> <li>• Эргэн мэдээлэл солилцсон тоо</li> </ul>
2.1.3.5	Үйлчлүүлэгчийн гомдол, санал хүсэлтийг шийдвэрт ашиглах, хариу арга хэмжээ авах	Чанарын алба Тасаг нэгжийн удирдлагууд	+	+	+	+	+		Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж, гомдол буурна.	<ul style="list-style-type: none"> <li>• Шийдвэрт ашигласан тоо</li> <li>• Гомдол буурсан тоо</li> </ul>
2.1.3.6	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, дэмжих бүлгийн ажилчдад чанарын СОРЕ ярилцлага хийх	Чанарын алба Тасаг нэгжийн удирдлагууд	+		+				Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын чанарын талаарх хандлага, ойлголт сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>• СОРЕ ярилцлага хийсэн тоо</li> <li>• Үр дүнгийн тайлан</li> </ul>
2.1.3.7	Чанарын удирдлагад “Гэрлэн дохионы систем”, “Хянах самбар”-ын аргыг нэвтрүүлэх	Чанарын алба	+	+	+	+	+		Чанарын хяналт сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагааны тайлан</li> <li>• Үр дүнгийн үзүүлэлт</li> </ul>
2.1.3.8	Чанар аюулгүй байдлын нийтлэг болон өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулж, тогтмол хэмжих	Чанарын алба Сувилахуйн алба	+	+	+	+	+		Шалгуур үзүүлэлтүүд оновчтой болно.	<ul style="list-style-type: none"> <li>• Шинэчилсэн шалгуурууд</li> <li>• Авсан арга хэмжээ</li> </ul>

2.1.3.9	Чанарын хяналтад “Тэнцвэрт онооны карт” боловсруулан, нэвтрүүлэх	Чанарын алба		+	+			Чанарын хяналт сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Тэнцвэрт онооны карт</li> <li>Үнэлгээний тайлан</li> </ul>
2.1.3.10	Чанарын сэдэвчилсэн (эмнэл зүйн, түгээмэл үйлдлийн ) ур чадварын тэмцээн зохион байгуулах	Чанарын алба		+		+		Тусламж, үйлчилгээний чанар сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Үр дүнгийн тайлан</li> </ul>
2.1.3.11	Чанарын удирдлагын дэвшилтэт арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн, үр дүнг тооцох	Чанарын алба	+	+	+	+	+	Тусламж, үйлчилгээний чанар сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Кайзан систем</li> <li>PDSA тогтолцоо</li> <li>Шалтгаан, үр дагаврын диаграмм</li> <li>Бэнчмаркингийн жишиг үзүүлэлт хэрэгжсэн тоо</li> <li>Статистик мэдээний хяналтын арга хэрэгслүүд нэвтэрсэн мэдээлэл</li> </ul>
2.1.3.12	Тусламж, үйлчилгээний тулгамдсан ноцтой асуудлуудыг шийдэх дэг, журам боловсруулан, хэрэгжүүлэх	Чанарын алба	+	+	+	+	+	Чанар, аюулгүй байдлын тулгамдсан асуудлыг цаг тухайд шийдвэрлэх боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Батлагдсан дэг, журам</li> <li>Хэрэгжилтийн тайлан</li> </ul>
2.1.3.13	Арьс гоо заслын эмчилгээний олон улсын эмнэл зүйн удирдамжуудыг орчуулан, боловсруулах	Ажлын хэсэг Чанарын алба	+	+				Арьс гоо заслын олон улсын эмнэл зүйн удирдамж нэвтрэх боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Орчуулж, боловсруулсан эмнэл зүйн удирдамж</li> <li>Баталсан тушаал</li> </ul>
2.1.3.14	Арьс гоо заслын эмчилгээ, оношилгоонд мөрдөж байгаа стандарт, эмнэл зүйн удирдамжуудыг үе шаттайгаар шинэчлэн, батлуулах	Удирдлагын зөвлөл Чанарын алба	+	+	+	+	+	Олон улсын стандарт, эмнэл зүйн удирдамж нутагших боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Шинэчилсэн стандарт, удирдамжийн тоо</li> <li>Батлагдан хэрэгжсэн стандарт, удирдамжийн тоо</li> </ul>
2.1.3.15	Оношилгоо, эмчилгээний стандартын мөрдөлтийг хяналтын хуудсаар тогтмол хянадаг тогтолцоонд шилжих	Чанарын алба	+	+	+	+	+	Оношилгоо, эмчилгээний чанар сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Хяналтын хуудаснууд</li> <li>Стандартын хэрэгжилтийн ахисан хувь</li> </ul>
2.1.3.16	Эмнэл зүйн аудит болон бусад үйл ажиллагаанд дотоод аудитыг нэвтрүүлэх	Удирдлагын зөвлөл Чанарын алба		+	+	+	+	Тусламж, үйлчилгээний чанар сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Дотоод аудит хариуцсан ажилтны тоо</li> <li>Үйл ажиллагааны тайлан</li> </ul>
2.1.3.17	Ижил мэргэжилтний үзлэгийн үр дүнг сайжруулах	Чанарын алба Сувилахуйн алба	+	+	+	+	+	Тусламж, үйлчилгээний үр дүн сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Батлагдсан удирдамж</li> <li>Үр дүнгийн ахисан үзүүлэлт</li> </ul>

2.1.3.18	Өвчний түүх, анхан шатны бичиг баримтын бичилтийн хяналтын үр дүнг сайжруулах	Чанарын алба Сувилахуйн алба	+	+	+	+	+	Өвчний түүх, анхан шатны бичиг баримтын хөтлөлт сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Хяналт хийсэн мэдээлэл</li> <li>Алдаа, зөрчил буурсан тоо</li> </ul>
2.1.3.19	Хэвтэн эмчлүүлэгчийн өвчний түүхийг нээх үйл явцад шинэлэг арга барил нэвтрүүлэх	Чанарын алба Сувилахуйн алба	+	+				Шуурхай байдал хангагдаж, ачаалал тэнцвэргинэ.	<ul style="list-style-type: none"> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>
2.1.3.20	Амбулатори, хэвтүүлэн эмчлэх тасгийн эмч нарын үйл явцын зураглал гарган, журам боловсруулан хэрэгжүүлэх	ХНМ Чанарын алба		+	+	+	+	Эмч нарын орлон ажиллах, хөрвөх чадвар нэмэгдэж, ачаалал тэнцвэргинэ.	<ul style="list-style-type: none"> <li>Зураглал гаргасан мэдээлэл</li> <li>Батлагдсан журам</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>
2.1.3.21	Сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллага, судлаачаар гүйцэтгүүлэх	Чанарын алба Сувилахуйн алба	+	+	+	+	+	Нотолгоонд үндэслэн шийдвэр гаргах боломж бүрдэнэ	<ul style="list-style-type: none"> <li>Судалгааны тайлан</li> <li>Зөвлөмжийн хэрэгжилт</li> </ul>
2.1.3.22	Эмнэлэг хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааг “Хяналтын хуудас”-аар хянах тогтолцоонд шилжих	Чанарын алба Сувилахуйн алба		+	+	+	+	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чирэгдэл буурна.	<ul style="list-style-type: none"> <li>Боловсруулсан хяналтын хуудас</li> <li>Чирэгдэл буурсан мэдээлэл</li> </ul>
<b>Стратегийн зорилт 2.1.4. Арьсны өвчний сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, сувилгаа, асаргааны үр дүнг дээшлүүлэх</b>			<b>Хүрэх үр дүн:</b> Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, сувилгаа, асаргааны үр дүн дээшилнэ.						
2.1.4.1	Сувилахуйн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Сувилахуйн алба	+	+	+	+	+	Сувилахуйн тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Нэмэгдсэн тусламж, үйлчилгээ</li> </ul>
2.1.4.2	Хүүхэд, эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчаар хангах	Захиргаа ХНМ	+	+	+	+	+	Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэшсэн сувилагчаар хангасан тоо</li> </ul>
2.1.4.3	Арьсны өвчний үед үзүүлэх хэсэг газрын эмчилгээ, сувилгааны зааврыг батлуулан, мөрдөж ажиллах	Сувилахуйн алба	+	+	+	+	+	Арьсны өвчний хэсэг газрын эмчилгээ, сувилгаа сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Зааврын тоо</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>
2.1.4.4	Өвчтөнийг ялган таних, бар Кодын систем нэвтрүүлэх	Чанарын алба Сувилахуйн алба		+	+	+	+	Өвчтөнийг ялган таних бар Кодын систем нэвтэрнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Таних, ялгах тэмдэглээсний систем нэвтэрсэн мэдээ, мэдээлэл</li> </ul>



2.1.4.5	“Найрсаг сувилахуй” шинэлэг арга барил нэвтрүүлэх уралдаан, өдөрлөг зохион байгуулах	Сувилахуйн алба	+		+				Сувилахуйн тусламж үйлчилгээнд шинэлэг арга барил нэвтрэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Уралдаан, өдөрлөгийн хөтөлбөр</li> <li>Арга хэмжээний тайлан</li> </ul>
2.1.4.6	Сувилагч мэргэжилтнүүдийг яаралтай амь тэнссэн үеийн тусламж үзүүлэх чадавхад сургах	Чанарын алба Сувилахуйн алба	+	+					Яаралтай амь тэнссэн үеийн тусламжийг шуурхай хүргэдэг болно.	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтад хамрагдсан сувилагчийн тоо</li> <li>Гардан үйлдлийн ур чадвар эзэмшсэн сувилагчдын тоо</li> </ul>
2.1.4.7	Сувилагч, мэргэжилтнүүдийн өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэгт удирдлагаар хангах	ХНМ Сувилахуйн алба	+	+	+	+	+		Сувилагч, мэргэжилтнүүд өөрийгөө хөгжүүлэх боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлсэн сувилагчдын тоо</li> <li>Байгууллагаас өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн тоо</li> </ul>
2.1.4.8	“Шилдэг багш-Шинэ сувилагч” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, сувилагч багш бэлтгэх	Удирдлагын зөвлөл Сувилахуйн алба	+	+	+	+	+		Сувилагч- сургагч багш бэлтгэгдэн, сургалт явуулах боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Сургагч багшаар бэлтгэгдсэн сувилагчийн тоо</li> <li>Сургагдсан сувилагчийн тоо</li> <li>Сургалтын гарын авлага</li> </ul>
2.1.4.9	“Арьс-харшлын тусламж үйлчилгээний сувилахуй-асаргааны онцлог” гарын авлага гаргах	Сувилахуйн алба			+				Орон нутгийн мэргэжил нэгтнүүдэд зориулсан гарын авлага гарна.	<ul style="list-style-type: none"> <li>Гарын авлагын тоо</li> <li>Түгээсэн тоо</li> </ul>
<b>Стратегийн зорилт 2.1.5. Эмнэлгийн халдвар, хамгаалал, ариутгалын аюулгүй байдлыг хангах</b>			<b>Хүрэх үр дүн: Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлж, аюулгүй тусламж, үйлчилгээ үзүүлнэ.</b>							
2.1.5.1	Халдвараас сэргийлэх стандартыг төрөлжүүлэх	Чанарын алба Тархвар судлаач	+	+					Халдвар хяналтын үйл ажиллагаа сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Стандартын төрөлжсөн тоо</li> </ul>
2.1.5.2	Олон улсын INICC сүлжээнд нэгдэх, хариу арга хэмжээ авах	ЭЭ захирал Тархвар судлаач			+	+	+	+	Олон улсын INICC сүлжээний гишүүн болсон байна.	<ul style="list-style-type: none"> <li>Сүлжээнд нэгдсэн, хариу арга хэмжээ авсан мэдээлэл</li> </ul>
2.1.5.3	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын үнэлгээ тогтмол хийх, онлайн веб сүлжээнд бүртгэдэг болох	ЭЭ захирал Тархвар судлаач			+	+	+	+	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын үнэлгээний тасралтгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний аргачлал</li> <li>Веб сүлжээнд бүртгэсэн мэдээлэл</li> </ul>
2.1.5.4	Олон эмд дасалтай MRSA болон VRE ESBL+Ecoli ESBL+ Klesiollaspp Asiretobac teriaspp-н идэвхтэй тандалтыг эхлүүлэх	ЭЭ захирал Тархвал судлаач	+	+					Идэвхтэй тандалт судалгаа хийдэг, мэдээлдэг болсон байна.	<ul style="list-style-type: none"> <li>Тандалт судалгаа хийсэн тоо</li> <li>Мэдээлсэн тоо</li> </ul>

2.1.5.5	Эмнэлгийн нэг удаагийн багаж, хэрэгслийн хангамж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	Санхүү, аж ахуйн тасаг Чанарын алба	+	+	+	+	+	Чанар, аюулгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Нэг удаагийн багаж, хэрэгслийн хангамжийн хувь, тоо</li> </ul>
2.1.5.6	Эм тариа, ороох боох материалын чанар, хадгалалтад хяналт тавьж, тасралтгүй байдлыг хангах	Чанарын алба Эм зүйн алба	+	+	+	+	+	Эм тариа, ороох боох материалын чанар, хангамж сайжирна	<ul style="list-style-type: none"> <li>Хяналтын тайлан</li> <li>Хангамжийн тайлан</li> </ul>
2.1.5.7	Ариутгал, боолт, эм, эмнэлгийн хэрэгсэл, материалыг нэг үйлчлүүлэгчээр тооцон савлаж, хэрэглэдэг тогтолцоонд шилжих	Ариутгалын хэсэг	+	+				Аюулгүй байдал хангагдаж, үр ашгийн хэмнэлт гарна.	<ul style="list-style-type: none"> <li>Зардлын харьцуулсан тооцоолол</li> </ul>
2.1.5.8	Эмнэлгийн болон ахуйн зориулалтын хог хаягдлын менежментийг төлөвлөн хэрэгжүүлэх	Халдвар хяналтын баг		+	+	+	+	Эмнэлгийн хог хаягдлын менежмент сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Эмнэлгийн болон ахуйн зориулалтаар ангилсан хогийн цэг</li> <li>Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан</li> </ul>
<b>Стратегийн зорилт 2.1.6. Аюулгүй, эрсдэлгүй тусламж, үйлчилгээг үзүүлэх</b>			<b>Хүрэх үр дүн: Эрсдэлгүй орчин бүрдэж, аюулгүй байдал хангагдана.</b>						
2.1.6.1	Эрсдэлийг бүртгэн мэдээлэх, тайлагнах, сан ажиллуулах журам боловсруулан хэрэгжүүлэх	ЭЭЗахирал Эрсдэлийн баг	+	+	+	+	+	Эрсдэлийн тандалт хийх үйл ажиллагаа сайжирна	<ul style="list-style-type: none"> <li>Эрсдэлийн тандалт хариуцсан ажилтан</li> <li>Батлагдсан журам</li> <li>Журмын хэрэгжилт</li> </ul>
2.1.6.2	Өндөр магадлалтай эрсдэлд хариу арга хэмжээ авах, стандарт хэмжээний Кодын системийн журам боловсруулан мөрдөх	ЭЭЗахирал, гамшгийн штаб	+	+	+	+	+	Гал болон амилуулах тусламжийн Кодын системийн журамтай болно.	<ul style="list-style-type: none"> <li>Батлагдсан кодын системийн журам</li> <li>Хэрэгжүүлсэн арга хэмжээ</li> </ul>
2.1.6.3	Тусламж, үйлчилгээ, орчны эрсдэлийн үнэлгээ хийх	Эрсдэлийн Баг	+		+		+	Тусламж, үйлчилгээний аюулгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний тайлан</li> <li>Хэрэгжилтийн тайлан</li> </ul>
2.1.6.4	Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, зөв хэрэглээг хангах	Чанарын алба	+	+	+	+	+	Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Эмч, мэргэжилтнийг сургалтад хамруулсан тоо</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>
2.1.6.5	Хоол үйлдвэрлэл, хоол хүнсний хадгалалтын аюулгүй ажиллагааг хангах	Санхүү аж ахуйн тасаг	+	+	+	+	+	Хоолны аюулгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Хяналт тавьсан тоо</li> <li>Санал, гомдлын тоо</li> </ul>
2.1.6.6	Төвийн гамшгийн штабын бүтэц, чиг үүргийг шинэчлэн баталгаажуулах	ЭЭЗахирал, Гамшгийн штаб	+	+	+	+	+	Гамшгийн штабын бүтэц, чиг үүрэг тодорхой болж, баталгаажсан байна.	<ul style="list-style-type: none"> <li>Баталсан шийдвэр</li> <li>Шинэчилсэн чиг үүрэг, бүтэц</li> </ul>

2.1.6.7	Онцгой байдлын гамшгийн үед ажиллах сургуулилыг жил бүр хийж, үр дүнг сайжруулах	ЭЭЗахирал, гамшгийн штаб	+	+	+	+	+	Онцгой үеийн чадавх нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Сургуулилт хийсэн тайлан, мэдээ</li> </ul>
<b>Стратегийн зорилт 2.1.7. Үйлчлүүлэгчид, ажилчдын аюулгүй байдлыг хангаж, дэмжлэгт орчныг бүрдүүлэх</b>					<b>Хүрэх үр дүн: Үйлчлүүлэгчид, ажилчдын аюулгүй байдлыг хангагдана.</b>				
2.1.7.1	“Өвчтөний аюулгүй байдлын төв” байгуулан, бусад эрүүл мэндийн байгууллагуудтай туршлага хуваалцах	Чанарын алба, Сувилахуйн алба	+	+	+	+	+	Өвчтөний аюулгүй байдал хангагдаж, зөвлөмж, мэдээллийг хүссэн цагт нь өгдөг болно.	<ul style="list-style-type: none"> <li>Үйл ажиллагааны тайлан</li> <li>Туршлага хуваалцсан ЭМБ-ын тоо</li> </ul>
2.1.7.2	Өвчтөн, тэдний ар гэрийнхэнд эмчилгээ, үйлчилгээний аюулгүй байдлын талаар зөвлөмж өгөх, туслан дэмжих үйлчилгээний журам гарган, мөрдөх	ЭЭ захирал Чанарын алба	+	+	+	+	+	Өвчтөний аюулгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Батлагдсан журам</li> <li>Хэрэгжилтийн тайлан</li> </ul>
2.1.7.3	Эмчлүүлэгч, эмнэлгийн орчинд осол, гэмтэлд өртөхгүй байх орчин бүрдүүлэх	Санхүү аж ахуйн тасаг		+	+	+		Эмчлүүлэгчийн аюулгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Гүйцэтгэлийн тайлан</li> </ul>
2.1.7.4	“Ажлын байрны аюулгүй байдал-Гар угаах хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэх	Чанарын алба Сувилахуйн алба	+	+	+	+	+	Ажлын байрны аюулгүй байдал сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Гар угаах хөтөлбөр</li> <li>Гар ариутгалыг хянасан тоо</li> </ul>
2.1.7.5	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангаж, хэрэглээний зөв, аюулгүй байдалд хяналт тавих	Санхүү аж ахуйн тасаг Чанарын алба	+	+	+	+	+	Ажилчдын аюулгүй байдал хангагдана	<ul style="list-style-type: none"> <li>Хангасан хувцас, хэрэгсэл</li> <li>Хяналт хийсэн тайлан</li> </ul>
2.1.7.6	Ажлын байран дахь үйлдвэрлэлийн ослыг хянаж урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Эрсдэлийн баг	+	+	+	+	+	Үйлдвэрлэлийн осол гарахаас сэргийлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан тоо</li> </ul>
2.1.7.7	Хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтны хор тайлах арга хэмжээ авах	ХНМ Санхүү аж ахуйн тасаг	+	+	+	+	+	Ажилчдын аюулгүй байдал хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>Хор тайлах сүү, бусад бүтээгдэхүүнээр хангасан тоо</li> </ul>

2.1.7.8	Үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх заавар, удирдамж, хяналтын хуудас боловсруулан, хэрэгжилтийг хангах	Чанарын алба Сувилахуйн алба	+	+	+	+	+	Үйлдвэрлэлийн ослоос сэргийлнэ	<ul style="list-style-type: none"> <li>• Ариутгал халдваргүйтгэлийн бодисыг найруулах заавар</li> <li>• Хурц үзүүртэй иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах заавар</li> <li>• Цусаар дамжих халдвараас сэргийлэх удирдамж</li> <li>• Тоног төхөөрөмжтэй харьцах зааврууд</li> <li>• Хяналтын хуудас</li> <li>• Авсан арга хэмжээний тайлан</li> </ul>
---------	--	---------------------------------	---	---	---	---	---	--------------------------------	---

### СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

#### Стратегийн зорилго 3.1. Тасралтгүй суралцагч байгууллага байж, зөв хандлагад суурилсан хүний нөөцийг хөгжүүлэх

#### Стратегийн зорилт 3.1.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг мэргэшсэн хүний нөөцөөр хангах

Хүрэх үр дүн: Хүний нөөцийн хөгжил хангагдана.

3.1.1.1	Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө, коучинг, менторын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	ХНМ Сургалтын алба	+	+	+	+	+	Хүний нөөцийн хөгжил хангагдана.	<ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр</li> <li>• Үр дүнгийн тайлан</li> </ul>
3.1.1.2	Шинэ хэрэгцээнд суурилан хүний нөөцийг төлөвлөн сургах	ХНМ Сургалтын алба	+	+	+	+	+	Эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын төлөвлөгөө</li> <li>• Сургалтын үр дүнгийн тайлан</li> </ul>
3.1.1.3	Өндөр хөгжилтэй оронд суралцан, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд дэмжлэгт удирдлагаар хангах	Захиргаа ХНМ	+	+	+	+	+	Технологийн дэвшил, инновац нэвтэрнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Сургасан хүний тоо</li> <li>• Нэвтрүүлсэн технологи, үйл ажиллагаа</li> </ul>
3.1.1.4	Тусламж, үйлчилгээний чанар, эрсдэл, аюулгүй байдал, халдвар хамгааллын сургалтуудыг өргөн хүрээгээр зохион байгуулах	Чанарын алба Сургалтын алба	+	+	+	+	+	Тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо</li> <li>• Хамрагдсан хүний тоо</li> </ul>
3.1.1.5	Эмч, мэргэжилтнүүдийг төлөвлөх, тайлагнах үр чадварт суралцуулах	ХНМ Сургалтын алба	+		+			Ажлаа зөв төлөвлөх, тайлагнах үр чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын тоо</li> <li>• Үр дүнгийн тайлан</li> </ul>
3.1.1.6	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг хамгаалахад дэмжлэгт удирдлагаар хангах, үр нөлөөллийг нэмэгдүүлэх	Захиргаа ХНМ	+	+	+	+	+	Хүний нөөцийн чадавх сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>• Шинээр эрдмийн болон мэргэжлийн зэрэг хамгаалсан хүний тоо</li> </ul>
3.1.1.7	“Шинэ ажилтныг чиглүүлэн сургах” хөтөлбөр хэрэгжүүлэн, ажлын байранд дадлагажуулах	Сургалтын алба Тасаг нэгжийн удирдлага	+	+	+	+	+	Шинэ ажилтны үр чадвар нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Батлагдсан хөтөлбөр</li> <li>• Дадлагажсан ажилтны тоо</li> </ul>

3.1.1.8	Үйлчилгээ, байгууллагын үнэт зүйл, соёлын сургалтуудыг зохион байгуулах	ХНМ Сургалтын алба	+	+	+			Үйлчилгээний соёл сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын тоо</li> <li>Хамрагдсан хүний тоо</li> </ul>
3.1.1.9	Эмч, мэргэжилтнүүдийг “Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө”-гөө хэрэгжүүлэхэд дэмжлэгт удирдлагаар хангах	Удирдлагын зөвлөл ХНМ			+	+	+	Хүний нөөцийн чадамж нэмэгдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжилтэн бүрийн хөгжлийн төлөвлөгөө</li> <li>Дэмжлэгт удирдлагаар хангасан хүний тоо</li> </ul>
3.1.1.10	“Шинэ санаа ба Үр ашиг” сэдэвт аян зохион байгуулах	Чанарын алба Сувилахуйн алба			+		+	Шинэ санаа нэвтрүүлэн үр ашигтай ажиллах боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Үйл ажиллагааны тайлан</li> </ul>
3.1.1.11	“Манай тасгийн брэнд үйлчилгээ” хөдөлгөөн өрнүүлэх	Санхүү, аж ахуйн тасаг Тасаг нэгжийн удирдлага			+	+	+	Шинэ санаа, брэнд үйлчилгээ нэвтрэх боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөр</li> <li>Шалгарсан тасаг, нэгжийг урамшуулсан тайлан, мэдээ</li> </ul>
<b>Стратегийн зорилт: 3.1.2. Хүний нөөцийн байршил, хангамжийг оновчтой болгож, бие даасан байдлыг хангах</b>			<b>Хүрэх үр дүн: Хүний нөөцийн байршил, хангамж оновчтой болж, бие даасан байдал хангагдана.</b>						
3.1.2.1	Ажлын байрны дүн шинжилгээ хийх	ХНМ ЭШС-ны баг			+		+	Ажлын байрны тодорхойлолтыг оновчтой боловсруулна.	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын байрны дүн шинжилгээ хийсэн тайлан</li> </ul>
3.1.2.2	Ажлын байрны шинжилгээнд үндэслэн АБТ-ыг шинэчлэн боловсруулах	ХНМ Тасаг нэгжийн удирдлага			+	+	+	Ажил, үүргийн хуваарь оновчтой болно.	<ul style="list-style-type: none"> <li>Шинэчилсэн ажлын байрны тодорхойлолтууд</li> </ul>
3.1.2.3	Ажиллах хүчний ачааллыг тэнцвэржүүлэх, хөрвөх, орлон ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах	Удирдлагын зөвлөл ХНМ			+	+		Ажлын ачаалал тэнцвэржин, хөрвөн, орлон ажиллах боломж бүрдэнэ	<ul style="list-style-type: none"> <li>Батлагдсан төлөвлөгөө , шийдвэр</li> <li>Үр дүнгийн тайлан</li> </ul>
3.1.2.4	Хүний нөөцийн сонгон шалгаруулалтад шинэлэг арга барил нэвтрүүлэх	ХНМ Тасаг нэгжийн удирдлага	+	+	+	+	+	Мэргэшлийн ур чадварыг бодитой үнэлэх боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Шинээр нэвтрүүлсэн аргын тоо</li> <li>Мэргэжлийн баримт бичгүүдийн баталгаажилт</li> </ul>
3.1.2.5	Эмч сувилагчийн харьцааг олон улсын түвшинд хүргэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Удирдлагын зөвлөл ХНМ			+	+	+	Сувилагчийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Эмч сувилагчийн харьцаа 1:2 болсон мэдээлэл</li> </ul>

3.1.2.6	Технологийн дэвшилтэй уялдуулан шаардлагатай хүний нөөцөөр үе шаттай хангах	Удирдлагын зөвлөл ХНМ	+	+	+	+	+	Шаардлагатай хүний нөөцөөр үе шаттай хангагдсан байна.	<ul style="list-style-type: none"> <li>• Арьс харшил, гоо засалч эмч</li> <li>• Хүүхдийн арьс, харшлын эмч</li> <li>• Нөхөн сэргээх эмч, сувилагч</li> <li>• Хүүхэд, эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчид</li> <li>• Клиникийн эм зүйч</li> <li>• Лабораторийн эмч, мэргэжилтэн</li> <li>• Сэтгэл зүйч</li> <li>• Мэдээллийн технологийн техникийн ажилтан</li> <li>• Эдийн засагч</li> <li>• .....</li> </ul>
<b>Стратегийн зорилт: 3.1.3. Эрдэм судлал, судалгаа, шинжилгээг хөгжүүлэх</b>			<b>Хүрэх үр дүн: Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа өргөжин, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах боломж бүрдэнэ.</b>						
3.1.3.1	Эмч, мэргэжилтнүүдийг судалгаа хийх үр чадварт сургах	Тасаг нэгжийн удирдлага	+	+	+	+		Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны арга зүйд суралцсан, чаддаг болсон эмч, мэргэжилтний тоо</li> </ul>
3.1.3.2	Монгол оронд зонхилон тохиолдож байгаа арьс харшлын өвчний тэргүүлэх шалтгаан, тархалтыг судлах	Нийгмийн ажилтан Судалгааны баг		+				Нотолгоонд тулгуурласан эмчилгээ, оношилгооны шийдвэр гаргах боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны тайлан</li> <li>• Зөвлөмж</li> </ul>
3.1.3.3	Эргэн хэвтэлтийн судалгаа хийж, шийдвэрт ашиглах	Эрдэм шинжилгээ судалгааны баг		+			+	Хүлээгдэл буурч, орны менежмент сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны тайлан</li> <li>• Хэрэгжүүлсэн арга хэмжээ</li> </ul>
3.1.3.4	Харшлын гаралтай өвчнүүдийн үеийн бодит хооллолтын шим тэжээлийн судалгаа хийх	Хоол зүйч Судалгааны баг	+					Эмчилгээний хоолны нэр төрөл нэмэгдэх боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны тайлан</li> <li>• Эмчилгээний хоолны нэр төрөл нэмэгдсэн тоо</li> </ul>
3.1.3.5	Ажилчдын халдварт өртөх эрсдэлийн судалгаа хийж, шийдвэрт ашиглах	Эрдэм шинжилгээ судалгааны баг	+					Нотолгоо, мэдээлэлтэй болно.	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны тайлан</li> <li>• Авсан арга хэмжээний мэдээ</li> </ul>
3.1.3.6	Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах	Эрдэм шинжилгээ судалгааны баг	+	+	+	+	+	Судалгааны үр дүнг ашиглах боломж бүрдэж, эмч мэргэжилтний судалгааны үр чадвар дээшилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Зохион байгуулсан хурал</li> <li>• Бүтээлийн товчоон</li> </ul>

<b>Стратегийн зорилт 3.1.4. Гүйцэтгэлийн удирдлагын оновчтой тогтолцоог нэвтрүүлэх</b>								<b>Хүрэх үр дүн: Гүйцэтгэлийг зөв үнэлдэг тогтолцоо бүрдэнэ.</b>	
3.1.4.1	Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд “Тэнцвэрт онооны карт”-ыг нэвтрүүлэх	ЭЭ захирал Тасаг нэгжийн удирдлага		+	+	+	+	Төлөвлөгөө, үйл ажиллагааны үнэлгээнд шинэ арга хэрэгсэл нэвтэрнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Тэнцвэрт онооны картад үндэслэсэн шалгуур үзүүлэлтүүд</li> <li>Үр дүнгийн тайлан</li> </ul>
3.1.4.2	Хүний нөөцийн гүйцэтгэлийн үнэлгээнд чанар, аюулгүй байдлын шалгуур оруулах	ЭЭ захирал Тасаг нэгжийн удирдлага	+	+	+	+	+	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Шалгуурын дагуу гүйцэтгэлийн үнэлгээ хийсэн тайлан, мэдээ</li> </ul>
3.1.4.3	Ажлын байрны тодорхойлолт, үүрэг, даалгавар, гүйцэтгэлтэй уялдуулан, мэдлэг, ур чадварын өөрийн үнэлгээ хийлгэх	ЭЭ захирал Тасаг нэгжийн удирдлага		+	+	+		Хувь хүнийг хөгжүүлэх боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний тайлан мэдээ</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>
3.1.4.4	Гүйцэтгэлийг чанар, үр дүнтэй уялдуулан цалин, урамшуулал олгох эрх зүйн орчныг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллах	ЭЭ захирал Тасаг нэгжийн удирдлага		+	+	+	+	Гүйцэтгэлийн чанар, үр дүн сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Шинээр гаргасан журам</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>
3.1.4.5	Эмч, эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тохиромжит хувилбарыг сонгож хэрэглэх	Захиргаа Санхүү						Эмч, мэргэжилтэн хариуцлагын даатгалд хамрагдах боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Даатгалд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо</li> </ul>
<b>Стратегийн зорилт 3.1.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, хариуцлагыг дээшлүүлэх</b>								<b>Хүрэх үр дүн: Байгууллагын эерэг зан үйл, уур амьсгал бүрдэж, хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.</b>	
3.1.5.1	Хууль зүйн зөвлөгөө өгөх, эвлэрүүлэн зуучлагчтай болох	ХНМ Ёс зүйн салбар хороо		+				Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа нэвтэрнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Шийдвэр</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>
3.1.5.2	Байгууллагын үйлчилгээний соёл, харилцааны стандарт боловсруулан мөрдүүлэх	Ёс зүйн салбар хороо	+	+	+	+	+	Ёс зүй, харилцаа сайжирч, гомдол буурна.	<ul style="list-style-type: none"> <li>Стандартыг хэвшүүлсэн тасаг нэгжийн тоо</li> <li>Гомдол буурсан тоо</li> </ul>
3.1.5.3	Эмч, мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлагын талаар хэрэглэгчдээс санал асуулга авч, шийдвэрт ашиглах	Ёс зүйн салбар хороо	+	+	+	+	+	Олон нийт үнэлгээнд үндэслэн шийдвэр гаргах боломж бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Үр дүнгийн тайлан, мэдээ</li> <li>Авсан арга хэмжээ</li> </ul>
3.1.5.4	Эмч, мэргэжилтний зөвлөгөө өгөх, ёс зүй, харилцааны ур чадварыг дээшлүүлэх сургалтыг давтамжтай зохион байгуулах	Ёс зүйн салбар хороо Сургалтын арга зүй	+	+	+	+	+	Эмч, мэргэжилтний зөвлөгөө өгөх, харилцаатай холбоотой гомдол буурна.	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын хөтөлбөр</li> <li>Тайлан</li> <li>Гомдол буурсан үзүүлэлт</li> </ul>



3.1.5.5	Гүйцэтгэлийн шалгуурт ёс зүй, харилцаа, зөвлөгөө өгөх ур чадварын үзүүлэлтийг оруулан, дүгнэх	ХНМ Тасаг нэгжийн удирдлага	+	+	+	+	+	Эмч, эмнэлгийн мэргэжилтний зөвлөгөө өгөх ур чадвар, ёс зүй, харилцааны соёл дээшилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</li> <li>Гүйцэтгэлийн үнэлгээний тайлан</li> </ul>
3.1.5.6	Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагаа, хяналт үнэлгээний тасралтгүй байдлыг хангах	Ёс зүйн салбар хороо	+	+	+	+	+	Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны үр дүн сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Үнэлгээний тайлан</li> <li>Үр дүнгийн үзүүлэлт</li> </ul>
3.1.5.7	Үйлчлүүлэгчдэд эерэг сэтгэгдэл төрүүлэх арга хэрэгслийг нэвтрүүлэх	Ёс зүйн салбар хороо	+	+	+			Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Нууц хадгалах</li> <li>Уучлал гуйх</li> <li>Эмчилгээ, үйлчилгээний зөвшөөрөл авах</li> </ul>
3.1.5.8	Ажилчдын ядаргаа, стресс тайлах гадаад, дотоодын аялал, зохион байгуулах	Захиргаа ХНМ	+	+	+	+	+	Хамт олны эвсэг уур амьсгал бүрдэнэ	<ul style="list-style-type: none"> <li>Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</li> </ul>
<b>Стратегийн зорилт 3.1.6. Хүний нөөцийн нийгмийн баталгааг сайжруулах</b>			<b>Хүрэх үр дүн: Ажиллах хүчний нийгмийн баталгаа сайжирч, бүтээмж нэмэгдэнэ.</b>						
3.1.6.1	Ажилчдыг орон сууцтай болгох орон сууцны зээлд хамруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Захиргаа ХНМ		+	+	+	+	Ажилчдын амьдралын баталгаа сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Дэмжлэг үзүүлсэн ажилтны тоо</li> </ul>
3.1.6.2	Ажилчдын хүүхдийн цэцэрлэгтэй болох, хувийн цэцэрлэгтэй гэрээтэй ажиллах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	ХНМ Санхүү, аж ахуйн тасаг		+	+	+		Ажилчдын хөдөлмөрийн бүтээмж, амьдралын баталгаа сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</li> </ul>
3.1.6.3	Нийгмийн баталгааг хангахад дэмжлэгт удирдлагаар хангах	ХНМ Санхүү, аж ахуйн тасаг	+	+	+	+	+	Ажилчдын амьдралын баталгаа сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Түлээ, нүүрсээр хангасан ажилчдын тоо</li> <li>Гэр, орон байртай болоход дэмжлэг үзүүлсэн хүний тоо</li> </ul>
3.1.6.4	Ажлын байрны эрүүл ая тухтай орчин бүрдүүлэх хөдөлгөөн зохион байгуулах, шалгарсан тасаг, нэгжийг урамшуулах	Удирдлагын зөвлөл Үйлдвэрчний эвлэл	+		+		+	Ажлын байрны эрүүл аюулгүй орчин бүрдэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Ая тухтай орчин бүрдүүлсэн хамт олны тоо</li> <li>Урамшуулсан хамт олны тоо</li> </ul>
3.1.6.5	Өрх толгойлсон, ганцаараа ажилладаг, амьдралын боломж багатай ажилтнуудыг дэмжлэгт удирдлагаар хангах	Захиргаа Үйлдвэрчний эвлэл	+	+	+	+	+	Ажилчдын сэтгэл ханамж дээшилнэ	<ul style="list-style-type: none"> <li>Дэмжлэг үзүүлсэн мөнгөн болон бусад үйл ажиллагааны үр дүн</li> </ul>



3.1.6.6	Ажилтны өвчлөлийн судалгаа хийж, эрүүлжүүлэх арга хэмжээ авах	ХНМ Үйлдвэрчний эвлэл	+	+	+	+	+	Ажилчид эрүүлжиж, нийгмийн баталгаа сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>Судалгааны тайлан</li> <li>Авсан арга хэмжээний тоо</li> </ul>
